

СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ ЗАРЛАЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Мэдээлэл, харилцаа холбооны системийн газардуулга, түүнд тавигдах шаардлага” стандартыг шинээр боловсруулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул уг үйлчилгээг үзүүлэх хүсэлтэй зөвлөхийн багийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөхийн баг нь тухайн стандартыг боловсруулах чадвартайг нотлох ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлага, боловсролын талаарх мэдээллийг ирүүлэх ба зөвлөхийн багт тавигдах дараах шаардлагыг хангасан байна.

Зөвлөхийн багт тавигдах шаардлага:

1. Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,
2. Харилцаа холбооны чиглэлээр 5-аас дээш жил ажилласан, техникийн болон онолын мэдлэг, туршлагатай,
3. Харилцаа холбооны чиглэлээр судалгаа шинжилгээ шинжилгээ, ном, сурах бичиг, стандарт, баримт материал орчуулах, боловсруулах, хянах зэрэг ажилд оролцсон, эрдмийн зэрэг цол хамгаалсан, харилцаа холбооны чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификаттай, эсхүл зөвлөх инженер бол давуу тал болно.
4. Асуудал шийдвэрлэх, системтэй дүн шинжилгээ хийх арга барил эзэмшсэн,
5. Мэргэжлийн англи хэлний зохих түвшний мэдлэгтэй.

Жич: Шаардлага тус бүрийг багийн гишүүдээс дор хаяж 1 хүн хангасан байна.

Сонирхсон этгээд мэдүүлгээ **2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор** ирүүлнэ үү.

Харилцаа холбооны зохицуулах хороо
Метро бизнес төв А блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033
Утас: 304258
Факс:327720

Харилцах албан тушаалтан:

Зохицуулалтын газрын
ТХТ-ийн Салбарын стандарт хариуцсан мэргэжилтэн М.Алгирмаа
Утас: 90089108
Мэйл хаяг: algirmaa@crc.gov.mn